



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/05

Мэргэн хошуу

**Ажил хүлээлцэх ажлын
хэсэг томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын түшмэл хур систем хариуцсан мэргэжилтэн Дамбын Наранцацрал өөр ажилд шилжин ажиллах болсон тул төлбөр тооцоо хариуцсан хариуцсан мэргэжилтэн Бэрхсайханы Аззаяад тоног төхөөрөмж болон холбогдох баримт бичгийг хүлээлцүүлсүгэй.

2.Б.Аззаяа, Д.Наранцацрал нарын ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: П.Ганхэт (Санхүүгийн албаны дарга)

Гишүүд: Н.Пүрэвсүрэн (Архив бичиг хэргийн ажилтан)

С.Батчимэг (Нярав)

3.Б.Аззаяа, Д.Наранцацрал нарын ажлын акт бүртгэл үйлдэж хүлээлцүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (П.Ганхэт)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ОТГОНЖАРГАЛ